

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2022.06.22-2022.09.22/**

2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2022 оны 03 дугаар улиралд нийт 44 албан бичиг ирсэн ба үүнээс хариутай бичиг 20, хариугүй бичиг 24 байгаагаас Удирдлагад 3, Захиргааны албанд 31, Үйлдвэрлэл, технологийн албанд 10 албан бичиг хуваарилагдан тус тус хугацаандаа, бүрэн шийдвэрлэгдсэн. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр өөрсөддөө хуваарилагдсан албан бичгээ түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

Албан бичгийн эхийг eDoc программаар боловсруулж хэвшсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд eDoc программын модулиудыг (эргэн танилцуулах, эргэн танилцуулах хэлбэр сонгох, хариутай бичгийн хариу сонгох, хамтран шийдвэрлэх) бүрэн ашиглахыг зорьж байна. Хариутай бичгийн шийдвэрлэлт 97.22%, хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 97.78%-тай, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.59 хоногтой байна.


Нийслэлийн Архивын газраас өгсөн чиглэлийн дагуу, Э-токен төхөөрөмж авахад шаардлагатай бичиг баримтуудыг зааврын дагуу бүрдүүлж Газрын дарга болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар Үндэсний Дата төвийн баталгаажуулсан 2 тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн авч үйл ажиллагаанд ашиглаж жигдэрсэн.

Манай байгууллагаас 2022 оны 03 дугаар улирлын байдлаар харилцан холбоотой ажилладаг яам, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 43 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулан графикаар харуулав.

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТ**

/2022 оны 03 дугаар улирлыг, 2021 оны 03 дугаар улирлынхтай харьцуулахад/



**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2022 оны 03 дугаар улирлыг, 2021 оны 03 дугаар улирлынхтай харьцуулахад,
тоон үзүүлэлтээр/

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2022 оны 03 дугаар улирал	44	20	24	3.59	43
2021 оны 03 дугаар улирал	47	25	22	3,57	33

Албан бичгийг хамгийн боломжит богино хугацаанд, чанартай шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оны мөн үед 3.57 байсан бол энэ онд 3.59 хоног байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил дутагдал, хугацаа хэтэрч хаагдаагүй болон хугацаа хэтэрч хаагдсан албан бичиг байхгүй.

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН



ТАЙЛАН ГАРГАСАН:
БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ, ГАДААД ХАРИЛЦАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.МӨНХДУЛАМ